

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2026.04.06

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Монгол Улсын валютын нөөц түүхэн дээд хэмжээнд хүрлээ.
- Бүртгэлийн өдөртэй холбоотой зах зээл огцом унав
- 4-р сарын сүүлээс эхлэн ТОП-20 индекс өсөлтийн шат руугаа орно.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-2.03%	-2.39%	-6.82%
MSE A	-4.66%	-1.12%	-8.10%
MSE B	-0.75%	-2.20%	0.87%

2026/03/30 – 2026/04/03

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
QPAY	9,087,526,920.87
KHAN	1,331,559,071.00
APU	764,245,184.12
GLMT	733,909,045.00
MNDL	507,070,452.93

2026/03/30 – 2026/04/03

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
UBH	53,000.00	21.34%
MSH	215.00	14.97%
HBO	57.41	14.96%
KEK	8,110.00	14.87%
ADU	358.00	14.38%

2026/03/30 – 2026/04/03

2026 он 04-р сарын 06

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,070

ТОП-20 индекс

50,762

MSE A

19,137

MSE B

14,487



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

6.8%

2025 - IV улирал

Инфляц

6.5%

2026-02 сар

ГВУН(сая\$)

7,187.76

2026-03 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.1%

USD/MNT

3,571.64

2026-04-05


 **Эдийн засгийн мэдээлэл****МОНГОЛ УЛСЫН ГВАН ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНДЭЭ ХҮРЛЭЭ**

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2026 оны эхний улирлын эцсийн байдлаар 7.19 тэрбум ам.долларт хүрч, оны эхнээс 182.5 сая ам.доллараар нэмэгдсэнээр түүхэн дээд түвшинд хүрээд байна. Энэхүү өсөлт нь зөвхөн хэмжээний хувьд бус, нөөцийн чанар, бүтэц сайжирсныг илтгэж байна.

Нөөцийн хүрэлцээг олон улсын шалгуураар үнэлбэл Монгол Улс импортын хэрэгцээг хэдэн сараар хангах, богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадварын хувьд хангалттай түвшинд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, гадаад орчны савлагаа, валютын урсгалын өөрчлөлт гарсан ч эдийн засгаа тогтвортой авч явах нөөц бүрдэж чаджээ.

Цаашид валютын нөөцийн тогтвортой өсөлтийг хадгалах, алт болон бусад активын зөв бүтэц бүрдүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдал, төгрөгийн ханшийн дархлааг хадгалах гол хүчин зүйл хэвээр байх юм.

График: Гадаад валютын нөөц /сая ам.доллар/

**МОНГОЛ БАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ**

Монголбанк 2026 оны 3 дугаар сард 949.5 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс нийт худалдан авалт 3.2 тоннд хүрснийг мэдээллээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 48 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дэлхийн зах зээл дээр алтны үнэ оны эхэнд түүхэн өндөр түвшинд хүрсэн ч сүүлийн саруудад буурч, савлагаатай байдалд шилжээд байна. Гэсэн хэдий ч үнийн түвшин өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байгаа нь дотоодын олборлогчдын идэвхийг нэмэгдүүлж байна.


Монголбанк 3 дугаар сард алт худалдан авах дундаж үнийг 560,486 төгрөгөөр тогтоосон нь нийлүүлэлт өсөхөд голлон нөлөөлсөн бөгөөд ингэснээр төв банкны алт худалдан авалт нэмэгдсэн байна.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 ИНДЕКСИЙН ХАНШИЙН ХӨДӨЛГӨӨН

График: ТОП-20 индекс




4-р сар дуусах хүртэл ханш бага зэрэг унах магадлалтай. Учир нь ногдол ашгийн бүртгэлийн өдөртэй холбоотой хөрөнгө оруулагч нар хувьцаагаа зардаг билээ. Мөн бүртгэлийн өдрийн дараа арилжааны идэвх ч гэсэн тодорхой хэмжээнд буурдаг. Эргээд 4-р сарын сүүл болон 5-р сараас эхлээд хувьцаануудын ханш өсдөг. Мөн 4-р сарын 30 гэхэд ихэнх ногдол ашиг хөрөнгө оруулагч нарын дансанд хуваарилагдах учир ногдол ашгийн мөнгөөрөө дахин хөрөнгө оруулах нь ашигтай.


ТОП-20 ИНДЕКСТ БАГТДАГ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Орлогын өсөлт
(өнгөрсөн оны мөн үеэс)

*Тэрбум төгрөг




Цэвэр ашгийн өсөлт
(өнгөрсөн оны мөн үеэс)



ТОП-20 компаниудын орлого 2025 онд өнгөрсөн онтойгоо харьцуулахад 13 орчим хувиар өссөн ч цэвэр ашгийн хэмжээ 12 хувиар буурлаа. Цэвэр ашгийн бууралтад Таван Толгой компанийн цэвэр ашиг 229 тэрбум төгрөгөөр буурсан нь голчлон нөлөөлөв.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

Ногдол ашигт суурилсан хөрөнгө оруулалт хийхэд мэдэж байх ёстой өдрүүд

Компаниудын хувьцааг эзэмшиж ногдол ашиг авахын тулд доорх өдрүүдийг зайлшгүй мэдэж байх ёстой. Монгол улсын хувьд Т+2 төлбөр тооцооны системийн дагуу гүйлгээ хийгддэг учраас бүртгэлийн өдрөөс 2 хоногийн өмнө тухайн хувьцааг худалдаж аван ногдол ашиг авах боломжтой болдог.

Зарлах өдөр /Declare date/	Хувьцаа авсан байх өдөр /Ex-Dividend date/	Бүртгэлийн өдөр /Record date/	Төлбөрийн өдөр /Payable date/
2026.02.19 өдөр ТУЗ-ийн тогтоолоор зарласан.	2026.03.20 өдөрт амжиж ХЭ болсон байх ёстой.	2026.03.22 өдөр ногдол ашиг авах эрхтэй ХЭ-н жагсаалт гаргана.	2026.04.30 өдөр ҮЦТХТ дансаар олгоно.

Энэ нь ямар нэг компанийн бодит жишээ биш бөгөөд зохиомол өдрүүд болно.

НОГДОЛ АШИГ ТАРААХАА ЗАРЛАСАН КОМПАНИУД

2026 оны 3-р сарын байдлаар ногдол ашиг тараахаа зарласан компаниудын дэлгэрэнгүй

№	Компанийн нэр	Шийдвэрийн огноо	Ногдол ашиг тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох (₮)	Нийт ногдол ашиг (₮)
1	Мандал Даатгал ХК	2026.01.30	2026.03.31 дотор	14.74	8,742,095,304.08
2	Ард Даатгал ХК	2026.02.02	2026.04.30	40	1,000,000,000.00
3	Сүү ХК	2026.02.03	2026.04.30 дотор	5.09	1,746,542,679.13
4	Тэнгэр Даатгал ХК	2026.02.05	2026.03.31 дотор	114.4	6,864,000,000.00
5	Тазар Шим Үйлдвэр ХК	2026.02.05	2026.04.30	2.49	2,983,301,885.00
6	Лэндмн ББСБ ХК	2026.02.06	2026.04.03	16.5	12,198,477,769.50
7	Хүрд ХК	2026.02.09	2026.06.01 дотор	3,800.00	514,010,800.00
8	Гутал ХК	2026.02.10	2026.04.30-с эхлэн	3,230.00	5,087,282,300.00
9	Материалимпекс ХК	2026.02.10	2026.04.30	150	205,230,900.00
10	Гермес Центр ХК	2026.02.11	2026.04.15 дотор	10.69	839,624,680.69
11	Мах Импекс ХК	2026.02.11	2026.08.01-с эхлэн	100	380,072,100.00
12	Баян Тээг ХК	2026.02.11	XXX дараа	3,960.00	1,000,327,680.00
13	Талх Чихэр ХК	2026.02.11	2026.08.01-с эхлэн	450	460,666,350.00
14	АПУ ХК	2026.02.12	2026.08.19 дотор	65	69,171,800,945.00
				65	69,171,800,945.00
15	Инновэйшн Инвестмент ХК	2026.02.12	2026.04.30 дотор	50	9,244,458,000.00
16	Монгол Шуудан ХК	2026.02.12	2026.04.30	1.5	149,379,544.50
17	Эрдэнэт Суврага ХК	2026.02.12	-	5	780,270.00
18	Улаанбаатар Хивс ХК	2026.02.12	2026.06.30 дотор	2,000.00	809,658,000.00
19	Айтүүлс ХК	2026.02.12	2026.04.30 дотор	4	137,808,496.00
20	Тавантолгой ХК	2026.02.12	2026.04.30 дотор	3,138.00	165,263,397,600.00
21	Монголын Хөрөнгийн Бирж ХК	2026.02.12	2026.04.30	43.44	15,224,136,134.16
22	Голомт Банк ХК	2026.02.13	2026.04.30 дотор	80	64,692,584,480.00
23	Монложистикс Холдинг ХК	2026.02.13	2026.04.30	5.8	2,269,152,832.60
24	Төрийн Банк ХК	2026.02.13	2026.04.30 дотор	51.8	39,113,985,750.00
25	Монголын Цахилгаан Холбоо ХК	2026.02.13	2026.04.30	0.47	12,218,940.09
26	Техник Импорт ХК	2026.02.13	2026.04.30	1,000.00	1,446,755,000.00
27	Инвескор ББСБ ХК	2026.02.13	2026.04.20	114.9	8,701,402,980.00
				850.00	2,040,000,000.00
28	Түмэн Шувуут ХК	2026.02.14	2026.04.30	21.8	4,360,000,000.00
29	Дархан Нэхий ХК	2026.02.15	2026.04.30 дотор	0.226	250,000,000.00
30	Тандэм Инвест ББСБ ХК	2026.02.15	2026.04.30	1.3	2,600,000,000.00
31	Тээвэр Дархан ХК	2026.02.16	2026.12.31 дотор	500	81,674,500.00
32	Бодь Даатгал ХК	2026.02.16	2026.04.30	5.85	1,356,798,385.80
33	Тах Ко ХК	2026.02.16	2026.05.01	108	114,919,128.00
34	Баянгол Зочид Буудал ХК	2026.02.16	2026.05.01	330	139,611,450.00
35	Хоринхоёрдугаар Бааз ХК	2026.02.16	-	188	498,419,960.00
36	Хас Банк ХК	2026.02.16	-	30	31,581,000,000.00
37	Хаан Банк ХК	2026.02.16	33X зөвшөөрлийн дараа	214	409,210,372,000.00
38	Монгол Алт ХК	2026.02.16	2026.04.30	500	132,926,000.00
39	Бидисек ҮЦК ХК	2026.02.16	2026.04.30	141.75	1,941,236,280.48
40	Монос Хүнс ХК	2026.02.16	2026.04.30	4.5	1,839,826,926.00
41	Ариг Гал ХК	2026.02.16	2026.05.30	125	423,666,400.00
42	Жуулчин Дюти Фрий ХК	2026.02.16	2026.04.30 дотор	4,280.00	279,749,360.00
43	Монгол Базальт ХК	2026.02.16	2026.04.30 дотор	2.61	147,248,370.00
44	Ард Кредит ББСБ ХК	2026.02.16	2026.04.30 дотор	3.04	1,106,560,000.00
45	Хөвсгөл Хүнс ХК	2026.02.16	2026.12.31 дотор	30	7,914,600.00
46	Женко Тур Бюро ХК	2026.02.12	2026.04.30	12.5	1,000,000,000.00
47	Худалдаа Хөгжлийн Банк ХК	2026.02.12	Аудитын дараа-	-	-